

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга.....	1
1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Орлого, зарлагын талаарх тайлбар, тодруулга.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал.....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	10
4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан .....	10
4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан .....	11
4.3 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан.....	12
4.4 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан .....	13
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	14

#### Товчилсон үгийн жагсаалт

ҮАГ	Үндэсний аудитын газар
САГ	Санхүүгийн аудитын газар
СТОУС	Санхүүгийн тайлангийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2020.03.13 № 06/856  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Буянт-Ухаа спортын ордон ТӨҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Буянт-Ухаа спортын ордон ТӨҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Буянт-Ухаа спортын ордон ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.


## Үүрэг, хариуцлага

Буянт-Ухаа спортын ордон ТӨҮГ-нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

*Ц.Н* Ц.НАРАНЧИМЭГ



## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Буянт-Ухаа спортын ордон ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус газрын захирал Л.Энхбаяр Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн анхан шатны баримтын бүрдэл хангасан баримтад үндэслэн ажил гүйлгээг бүртгэлд тусгаж байх зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Буянт-Ухаа спортын ордон ТӨҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Буянт-Ухаа спортын ордон ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Буян-Ухаа спортын ордон ТӨҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 17-ноос 2020 оны 3-р сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар Стандарт дүгнэлт аудит ХХК-ийн аудитор А.Цэрэнчимэд, аудиторов туслах Б.Анармаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Буянт-Ухаа спортын ордон ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланг Стандарт дүгнэлт аудит ХХК-д 2020 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 20/26 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Буянт-Ухаа спортын ордон ТӨҮГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Олон улс, тив, дэлхийн тэмцээн уралдаан, соёл урлагийн арга хэмжээ хурал зөвлөгөөнийг эх орондоо өндөр түвшинд зохион байгуулах, ордныг үр ашигтай ажиллуулж, зөв удирдлага менежментээр удирдан, дэлхийн жишигт хүргэж хөгжүүлэх, эрхэм зорилготой байна.” гэжээ.

Буянт-Ухаа спортын ордон ТӨҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Биеийн тамир, спортын талаар төрөөс явуулж буй бодлогын хэрэгжилтийг хангах
- Төрөөс баримтлах бодлогод тусгасан зорилгыг хэрэгжүүлэх
- Иргэдийн дунд нийтийг хамарсан биеийн тамир, спорт чийрэгжилтийн арга хэмжээ болон олон улс, тив, дэлхийн тэмцээнийг зохион байгуулах
- Соёл урлагийн болон бусад арга хэмжээг зохион байгуулах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Буянт-Ухаа спортын ордон ТӨҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Leader-3” программ хангамж ашигладаг байна.

Буянт-Ухаа спортын ордон ТӨҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

#### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Буянт-Ухаа спортын ордон ТӨҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөлтийн үе шатанд 36 асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

#### **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

**Буянт-Ухаа спортын ордон ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,095.4 сая төгрөгөөс тооцон 21.9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 2,591.3 сая төгрөгөөс тооцон 51.8 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

## **2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд**

Буянт-Ухаа спортын ордон ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 93.5 сая төгрөгөөр буюу 0.19 хувиар буурсан байна.

### **Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт**

/сая төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	37.2	305.4	268.2
Авлага	144.0	211.2	67.2
Урьдчилж гарсан зардал	2.3	-	(3.7)
Бараа материал	100.1	96.4	7.0
Үндсэн хөрөнгө	49,668.4	49,245.4	(423.0)
Биет бус хөрөнгө	460.5	460.5	-
<b>Нийт хөрөнгө</b>	<b>50,412.4</b>	<b>50,318.9</b>	<b>(94.5)</b>
Өр төлбөр	234.9	520.4	285.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	50,177.5	49,798.5	(379.0)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>50,412.4</b>	<b>50,318.9</b>	<b>(93.5)</b>

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, нийт өр төлбөрийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 268.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд орлого 55 хувиар өссөн, мөн тайлант онд төлөх нэмэгдсэн өртгийн албан татварын өрийг Сангийн яам болон татварын байгууллагатай зөвшилцөн хойшлуулсантай холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 67.2 сая төгрөгөөр өссөн нь томоохон байгууллагуудын 12 дугаар сард зохион байгуулагддаг шинэ жилийн арга хэмжээний төлбөрийг гэрээ дүгнэсний дараа хийдэгтэй холбоотой байна.

Урьдчилж гарсан зардал нь тайлант хугацааны зардал болон хасагдсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл буурсан нь 6.8 сая төгрөгийн орлого олох зориулалтаар худалдан авсан хөрөнгө, хуримтлагдсан элэгдэл 440.5 сая төгрөгөөр нэмэгдсэнээс тус тус шалтгаалжээ.

Богино болон урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 285.5 сая төгрөгөөр өссөн нь БНХАУ-ын Худалдааны яам, Монголын талаас Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ТӨБЗГ хоёрын хооронд байгуулсан гэрээгээр Буянт-Ухаа спортын ордон ТӨҮГ-ын барилгад их засвар хийхтэй холбогдон гарах Монголын талын хариуцах зардлыг урьдчилан тус газраас гаргахаар шийдвэрлэж, тайлант оны татварын өрийг хойшлуулсантай холбоотой байна. Үүнд НӨАТ болон бусад татварын өр 199.3 сая төгрөгийг хойшлуулсан ба бусад нь харилцагч байгууллагад төлөх өр төлбөр байна. Хойшлогдсон татварын өр төлбөр нийт өр төлбөрийн 70.0 хувийг эзэлж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 49,798.5 сая төгрөг болж 379.0 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд алдагдалтай ажилласнаас шалтгаалжээ. Энэ нь ерөнхий удирдлагын зардал нь өмнөх оноос 711.6 сая төгрөгөөр буюу 37.9 хувиар өссөнтэй холбоотой байна.

## 2.9. Орлого, зарлагын талаарх тайлбар, тодруулга

Тус ТӨҮГ-нь тайлант онд 2,212.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны зардалд 2,591.3 сая төгрөгийг зарцуулж, 379.0 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ. Орлого нь өмнөх оныхоос 729.2 сая төгрөг, зардал нь 709.3 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Буянт-Ухаа спортын ордон ТӨҮГ-ын 2019 оны төсвийг батлахдаа 1,500.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 1,798.1 сая төгрөгийн зарлага гаргаж, 298.1 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар тооцож, төлөвлөсөн байна.

Батлагдсан төсвийг гүйцэтгэлтэй харьцуулахад орлогыг 147.5 хувь буюу 712.3 сая төгрөгөөр илүү төвлөрүүлж, зардлыг 144.1 хувь буюу 793.2 сая төгрөгөөр илүү зарцуулж, 379.0 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

2019 оны зорилтот түвшинд татварын өмнөх ашгаас элэгдлийн зардлыг хасаж тооцсон цэвэр ашиг, алдагдал нь 147.6 сая төгрөгөөр батлагдсан ба гүйцэтгэлээр 66.5 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Хүснэгт 1. Зорилтот түвшин, гүйцэтгэл

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөгөөр/	
			Өөрчлөлт	Хувь
Б	1	2	3=2-1	
Нийт орлого	1,500.0	2,212.3	712.3	147.5
Нийт зардал	1,798.1	2,591.3	793.2	144.1
Элэгдлийн зардал	445.7	445.5	(0.2)	100.0
Үйл ажиллагааны зардал	1,352.4	2,145.8	793.4	158.7
Татварын өмнөх ашиг	(298.1)	(379.0)	(80.9)	127.1
Татварын зардал	-	-	-	
Цэвэр ашиг алдагдалд элэгдлийн зардал ороогүй	147.6	66.5	(81.1)	45.0

## 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 36 эрсдэл тодорхойлж нийт 36 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 19.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 13.7 сая төгрөгийн алдааг залруулж, 6.2 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж, 1 албан шаардлага өглөө. Үүнд:

1. Эд хогшил, тоног төхөөрөмж бүхий 10.7 сая төгрөгийн хөрөнгийг хангамжийн материалд ангилал сольж бүртгэсэн. Энэ нь үнэн зөв, толилуулаг ба тодруулга гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 361-р тушаалын 9.1-д заасан НББОУС 16 “Үндсэн хөрөнгө” дагаж мөрдөнө гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

2. Кассын тайлангийн үлдэгдэл 3.0 сая төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн. Энэ нь үнэн зөв, толилуулаг ба тодруулга гэсэн батламж мэдэгдэл, мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.2-д “Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

3. 2019 оны батлагдсан зорилтот түвшинд хүрч ажиллаагүйгээс алдагдалтай ажилласан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2-д “Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, хүргэх түвшин” гэсэн заалттай нийцэхгүй байна.



Шийдвэрлэсэн нь: Хуулийн заалтыг хэрэгжүүлж, батлагдсан зорилтот түвшинд хүрч ажиллан эдийн засгийн үзүүлэлтийн үр ашгийг дээшлүүлж ашигтай ажиллах албан шаардлага өгсөн.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Тус ТӨҮГ-нь 2016-2019 онуудад дараалан 822.0-379.0 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, тайлант онд авлага 66.3 сая төгрөг, өр төлбөр 284.5 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна. Нийт зардлын өсөлтийн 78.8 хувь буюу 575.2 сая төгрөгийн зардал нь борлуулсан барааны өртгийн өсөлт байна. 2018 онд шинэ жилийн хүлээн авалтын арга хэмжээ есийг зохион байгуулж байсан бол тайлант онд арван дөрөв болж нэмэгдсэнтэй холбоотой байна.

Иймд тус газрын удирдлагууд үйл ажиллагаандаа дүн шинжилгээ хийж, төлөвлөгөөт зорилтыг барьж, зардлыг хэмнэх замаар батлагдсан зорилтод хүрч ажиллах шаардлагатай байна. Цаашид байгууллагын удирдлага ТӨБЗГазартай байгуулсан үр дүнгийн гэрээгээ дүгнэж, зорилтот түвшиндээ хүрч ажиллах шаардлагатай байна.

Бид алдагдалтай ажилласан талаар дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц асуудалд оруулж өгсөн бөгөөд 2019 онд батлагдсан зорилтод түвшингээс 80,9 сая төгрөгөөр илүү алдагдалтай ажилласан нь аудит хийсэн санхүүгийн тайланд нөлөөлөхгүй гэж үзсэн тул зөрчил гэж үзэх боломжгүй байна.

Ерөнхий удирдлагын зардал өнгөрсөн оноос 119.2 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь цалингийн зардал 131,3 сая төгрөг, элэгдлийн зардал 36.3 сая төгрөг, түрээсийн зардал 6.3 сая төгрөгөөр өссөн, шинэ жил хүлээн авалтын арга хэмжээний орлого 55 хувиар өссөнтэй холбоотой байна.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 28 мэдээллийг хугацаанд нь, 14 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2 албан шаардлага, 1 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Буянт-Ухаа спортын ордон ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Буянт-Ухаа спортын ордон ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, СТОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Залруулаагүй 6.2 сая төгрөгийн алдаа зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

### 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1. Зардлын данстай холбоотой асуудал

**3.1.1 Илрүүлэлт:** Анхан шатны маягт бүртгэлийг батлагдсан маягт аргачлалаар хөтөлж, баталгаажуулаагүй, баримтын бүрдэл дутуу баримтаар 6.2 сая төгрөгийн (*сэлбэг хэрэгсэл болон бараа материал худалдан авахдаа*) ажил гүйлгээ хийсэн.

Энэ нь үнэн зөв гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*" заалт зөрчсөн байна.

**3.1.2. Эрсдэл:** Анхан шатны дэмжих баримтгүй болон бүрдэл дутуу баримтаар зардлын гүйлгээ хийгдсэн байх, хуулийн заалт хэрэгжихгүй байх;

**3.1.3. Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д заасныг хэрэгжүүлж, анхан шатны иж бүрэн баримтаар дэмжигдсэн гүйлгээг зардлаар бүртгэж байх, дотоод хяналтыг сайжруулах.

**3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, давтан гаргахгүй ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

Тайлангийн хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	37,215,894.05	305,426,200.20
Дансны авлага	143,956,103.62	211,206,697.79
Бараа материал	100,097,726.46	96,408,497.36
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,257,120.00	
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>283,526,844.13</b>	<b>613,041,395.35</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
Үндсэн хөрөнгө	49,668,374,949.66	49,245,312,546.38
Биет бус хөрөнгө	460,537,083.58	460,537,083.58
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>50,128,912,033.24</b>	<b>49,705,849,629.96</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>50,412,438,877.37</b>	<b>50,318,891,025.31</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>Өр төлбөр</b>		
<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
Дансны өглөг	52,645,908.96	136,225,644.81
Татварын өр	164,788,572.64	364,078,934.22
Урьдчилж орсон орлого	17,500,000.00	20,100,000.00
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>234,934,481.60</b>	<b>520,404,579.03</b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>234,934,481.60</b>	<b>520,404,579.03</b>
<b>Эздийн өмч</b>		
Өмч: - төрийн	29,408,582,053.34	29,408,582,053.34
- хувийн		
- хувьцаат		
Эздийн өмчийн бусад хэсэг	458,640,000.00	458,640,000.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	25,938,458,763.97	25,938,458,763.97
Хуримтлагдсан ашиг	(5,628,176,421.54)	(6,007,194,371.03)
Тайлант үеийн ашиг/алдагдал		
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>50,177,504,395.77</b>	<b>49,798,486,446.28</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>50,412,438,877.37</b>	<b>50,318,891,025.31</b>

#### 4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлангийн хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>1,463,987,237.06</b>	<b>2,211,597,315.74</b>
Борлуулалтын өртөг	786,608,245.07	1,379,057,905.47
<b>Нийт ашиг ( алдагдал)</b>	<b>677,378,991.99</b>	<b>832,539,410.27</b>
Хүүгийн орлого	63,825.13	-
Бусад орлого	19,019,663.91	346,034.27
Борлуулалт, маркетингийн зардал	-	-
Ерөнхий ба удирдлагын зардал	1,093,057,001.45	1,212,251,366.03
Санхүүгийн зардал	-	-
Бусад зардал	2,302,000.00	-
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
Бусад алдагдал	-	-
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал)</b>	<b>(398,896,520.42)</b>	<b>(379,017,949.49)</b>
Орлогын татварын зардал		
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(398,896,520.42)</b>	<b>(379,017,949.49)</b>
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)	(398,896,520.42)	379,017,949.49)
<b>Орлогын нийт дүн</b>	<b>(398,896,520.42)</b>	<b>(379,017,949.49)</b>
<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

### 4.3 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

Тайлангийн хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Мөнгөн орлогын дүн (+)	<b>1,551,408,532.05</b>	<b>2,263,050,735.95</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,535,744,624.46	2,251,629,302.47
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	3,725,843.00	2,730,365.00
Бусад мөнгөн орлого	11,938,064.59	8,691,068.48
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>1,546,131,326.30</b>	<b>1,995,936,464.07</b>
Ажиллагчдад төлсөн	206,820,778.65	300,582,962.29
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	57,799,479.76	82,568,999.52
Бараа материал худалдан авахад төлсөн	952,189,882.71	1,310,832,407.97
Ашиглалтын зардалд төлсөн	203,766,881.10	220,347,407.37
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	6,848,100.00	5,027,500.00
Татварын байгууллагад төлсөн	91,928,735.30	50,777,951.13
Бусад мөнгөн зарлага	26,777,468.78	25,799,235.79
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>5,277,205.75</b>	<b>267,114,271.88</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Мөнгөн орлогын дүн (+)	<b>240,714.86</b>	<b>2,896,034.27</b>
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	94,500.00	2,550,000.00
Биет бус хөрөнгө борлуулсны орлого	110,000.00	
Хүлээн авсан хүүний орлого	36,214.86	346,034.27
Хүлээн авсан ногдол ашиг	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	<b>5,883,592.00</b>	<b>1,800,000.00</b>
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	5,883,592.00	1,800,000.00
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(5,642,877.14)</b>	<b>1,096,034.27</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Мөнгөн орлогын дүн (+)	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	<b>11,245,779.03</b>	-
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	4,039,299.03	-
Төлсөн ногдол ашиг	7,206,480.00	-
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(11,245,779.03)</b>	-
<b>Валютын ханшийн зөрүү</b>	-	-
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(11,611,450.42)</b>	<b>268,210,306.15</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>48,827,344.47</b>	<b>37,215,894.05</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>37,215,894.05</b>	<b>305,426,200.20</b>

#### 4.4 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлангийн хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2017-12-31-ний үлдэгдэл</b>	<b>29,362,995,053.34</b>	-	-	<b>(5,194,489,138.85)</b>	<b>24,168,505,914.49</b>
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>29,362,995,053.34</b>	-	-	<b>(5,194,489,138.85)</b>	<b>24,168,505,914.49</b>
НББ-ийн өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(34,790,762.27)	(34,790,762.27)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(398,896,520.42)	(398,896,520.42)
<b>Өмчид гарсан өөрчлөлт</b>	<b>45,587,350.00</b>	-	-	-	<b>45,587,350.00</b>
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	25,938,458,413.97	458,640,000.00	-	26,397,098,413.97
<b>2018-12-31-ний үлдэгдэл</b>	<b>29,408,582,403.34</b>	<b>25,938,458,413.97</b>	<b>458,640,000.00</b>	<b>(5,628,176,421.54)</b>	<b>50,177,504,395.77</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(379,017,949.49)	(379,017,949.49)
<b>2019-12-31-ний үлдэгдэл</b>	<b>29,408,582,403.24</b>	<b>25,938,458,413.97</b>	<b>458,640,000.00</b>	<b>(6,007,194,371.03)</b>	<b>49,798,486,446.28</b>

**Буянт-Ухаа спортын ордон ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

**5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо:	Аудитын нэр:	<i>Буянт-Ухаа спортын ордон ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит</i>	Аудитын код
2020-03-10			САГ-2020/43СТА-ТӨААТҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	<i>Буянт-Ухаа спортын ордон ТӨҮГ</i>		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны нэр	
				4	5
	1	2	3	4	5
1	Материалын дансанд эд хогшил, тоног төхөөрөмж бүртгэсэн	10.7	Залруулга	Буянт-Ухаа спортын ордон ТӨҮГ-ын захирал, нягтлан бодогч	Л.Энхбаяр Н.Баатаргэрэл
2	Анхан шатны баримтын бүрдэл хангаагүй	6.2	Зөвлөмж өгөх	Буянт-Ухаа спортын ордон ТӨҮГ-ын захирал, нягтлан бодогч	Л.Энхбаяр Н.Баатаргэрэл
3	Кассын тайлангийн үлдэгдэл дутуу илэрхийлэгдсэн	3.0	Залруулга	Буянт-Ухаа спортын ордон ТӨҮГ-ын захирал, нягтлан бодогч	Л.Энхбаяр Н.Баатаргэрэл
4	2019 оны зорилтот түвшинд хүрч ажиллаагүй ба алдагдалтай ажилласан	0.0	Албан шаардлага	Буянт-Ухаа спортын ордон ТӨҮГ-ын захирал, нягтлан бодогч	Л.Энхбаяр Н.Баатаргэрэл
	<b>ДҮН</b>	<b>19.7</b>			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 18

№ 02/135

Улаанбаатар хот

с/тг-2020/43/СТА-ТӨЧГ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийсэн Буянт-ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Буянт-Ухаа спортын ордон ТӨҮГазар нь 2019 оны батлагдсан зорилтот түвшинд хүрч ажиллаагүйгээс алдагдалтай ажилласан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2-д "Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, хүргэх түвшин" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т заасан "аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах акт тавих, зөрчлийг барагдуулах албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1 –д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан зорилтот түвшинд хүрч ажиллан, цаашид эдийн засгийн үзүүлэлтийн үр ашгийг дээшлүүлж ашигтай ажиллах.
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор гаргаж, Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Буянт-Ухаа спортын ордон ТӨҮГ-ын захирал Л.Энхбаяр, нягтлан бодогч Н.Баатаргэрэл нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

*[Signature]*

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР

*[Signature]*

Ц.ЭНХЖАРГАЛ

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭЛТГЭСЭН  
СТАНДАРТ ДҮГНЭЛТ АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ  
АУДИТОР

*[Signature]*

В.ДАВААСҮРЭН

А.ЦЭРЭНЧИМЭД

*[Signature]*

ЗӨВШӨӨРСӨН:

БУЯНТ-УХАА СПОРТЫН ОРДОН  
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ

*[Signature]*

Л.ЭНХБАЯР

НЯГТЛАН БОДОГЧ

*[Signature]*

Н.БААТАРГЭРЭЛ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10\Richie\_Kheree\Alban Shaardlaga\2020\0318SAG4.Docx

001080454